

ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Мянган сутаин буян ОНӨААТҮГ-ын
2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХОА-2026/009/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас: www.audit.mn Ховд хот 2026 он	Дарга, тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар Утас: 70433061 Цахим хаяг: boldbaatarkhu@audit.gov.mn Аудитын менежер: А.Цэцэгсүрэн Утас: 70432545 Цахим хаяг: tsetsegsurena@audit.gov.mn Аудитор: Ц.Азжая Утас: 70432545 Цахим хаяг: azzayats@audit.gov.mn
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд аймаг
Утас/Факс: (976)-7043-3061
Email: khovd@audit.gov.mn

2026.03.13 № 236

танай _____ -ны № _____ -т

МЯНГАН СҮТАЙН БУЯН ОНӨААТҮГ-ЫН
ДАРГА Я.МЯГМАРДОРЖ ТАНАА

Сөрөг дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Мянган сүтэйн буян ОНӨААТҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь санхүүгийн тайланд материаллагаар нөлөөлсөн бөгөөд өргөн тархсаныг хангалттай, зохистой аудитын нотолгоонд үндэслэн нотолсны улмаас Мянган сүтэйн буян ОНӨААТҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулаагүй гэж үзсэн.

Сөрөг дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн доорх зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс их, аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн мэдэгдэхүйц нөлөөллийг тооцон Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3, 20 дугаар зүйлийн 20.1.3, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3, 10.12, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, 20 дугаар зүйлийн 20.2.3, МУ-ын Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 02 дугаар тогтоолын хавсралт дахь заалттай нийцээгүй санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг, батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

- 2025 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулан батлуулаагүй;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг зөрчин бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар баримтлаагүй 130.0 сая төгрөгийн тээврийн хэрэгсэл худалдан авсан;
- Сумын ОНХС-гаас үйл ажиллагааны зардлын дэмжлэгээр 200.0 сая төгрөг батлуулан и-баримт үүсгэн орлого бүртгэж, автомашиныг НӨАТ төлөгч биш иргэнээс шууд худалдан авсантай холбоотой худалдан авалтын НӨАТ шивүүлээгүй, татварын 11.8 сая төгрөгийн татварын өр үүсгэсэн;
- Түрээсийн орлогыг дутуу төвлөрүүлсэн 0.8 сая төгрөгөөр дутуу төвлөрүүлсэн,
- Орон нутгийн нэмэгдэл авах эрхгүй албан тушаалтнуудад 22.4 сая төгрөгийн орон нутгийн нэмэгдэл тооцон олгосон;

- Урд оноос авлага, өр төлбөр 33.8 сая төгрөгөөр нэмэгдсэн;

Асуудлыг онцолсон хэсэг

Мянган сүтэйн буян ОНӨААТҮГ нь 2025 онд 9 түрээслэгчтэй 17.6 сая төгрөгийн гэрээ байгуулж 17.2 сая төгрөгийг төвлөрүүлж, айл өрхийн хог хаягдал ачсаны хураамжаар 10.6 сая төгрөг, аж ахуй нэгжийн халаалтаас 119.7 сая төгрөгийг тус тус бүрдүүлжээ.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант онд сумын ОНХС-ын хөрөнгө оруулалтаар 130.0 сая төгрөгийн, 3 автомашин худалдан авсан боловч сумын ЗДТГ-ын үндсэн хөрөнгөд орлого авсан байна.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБӨУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:  БОЛДБААТАР



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

(төгрөгөөр)

Дансны код	Дансны нэр, төрөл	1. Эхний үлдэгдэл	2. Эцсийн үлдэгдэл
1	1.1 ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	9000	4008700
31	1.1.1 МӨНГӨН ХӨРӨНГӨ	9000	8700
31200	1.1.1.02 Банкинд байгаа бэлэн мөнгө	9000	8700
31210	1.1.1.02.01 Төгрөг	9000	8700
31213	1.1.1.02.01.03 Арилжааны банк дахь харилцах	9000	8700
33	1.1.3 АВЛАГА	0	4000000
33500	1.1.3.07 Бусад авлага	0	4000000
33510	1.1.3.07.01 Байгууллагаас авах авлага	0	4000000
2	1.2 ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1839920.08	6129940.16
39	1.2.2 ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1839920.08	6129940.16
39200	1.2.2.02 Биет хөрөнгө	1839920.08	6129940.16
39205	1.2.2.02.05 Машин тоног төхөөрөмж(компьютер)	2299900	7049900
39206	1.2.2.02.06 Хуримтлагдсан элэгдэл	-459979.92	-919959.84
3	1 НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2	1848920.08	10138640.16
4	2.1 НИЙТ ӨР ТӨЛБӨР	11977393.94	53179183.02
41	2.1.1 БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	11977393.94	53179183.02
41300	2.1.1.03 Өглөг	11977393.94	53179183.02
41310	2.1.1.03.01 Ажилчидтай холбогдсон өглөг	5392476.07	0
41360	2.1.1.03.06 Бусад өглөг	6584917.87	53179183.02
41361	2.1.1.03.06.01 Байгууллагад төлөх өглөг	0	6883840
41363	2.1.1.03.06.03 Татварын өглөг /ТӨҮГ/	6584917.87	46295343.02
5	2.2 ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	-10128473.9	-43040542.9
51	2.2.1 Засгийн газрын хувь оролцоо	-10128473.9	-43040542.9
51200	2.2.1.08 Хуримтлагдсан үр дүн	-10128473.9	-43040542.9
51210	2.2.1.08.01 Өмнөх үеийн үр дүн	702590.37	-10831064.2
51220	2.2.1.08.02 Тайлант үеийн үр дүн	-10831064.2	-32209478.6
6	2 ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5	1848920.08	10138640.16

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Дансны нэр, төрөл	1. Өмнөх он	2. Тайлант он
I	1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	-10371084	-32209479
12	1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-10371084	-32209479
120	1.1.1.04.1 Нийтлэг татварын бус орлого	-10371084	-32209479
120010	1.1.1.04.1.10 Борлуулалтын орлого (Цэвэр) /ТӨҮГ/	156408465	395593968
120011	1.1.1.04.1.11 Борлуулалтын өртөг /ТӨҮГ/	166779549	427803446
II	1.1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	459979.92	0
21	1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ	459979.92	0
210	1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	459979.92	0
2109	1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал	459979.92	0
210903	1.1.2.01.1.09.03 Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	459979.92	0
III	1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	-10831064	-32209479
VI	1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)	-10831064	-32209479

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

(Төгрөгөөр)

Дансны код	Дансны нэр, төрөл	1.3 Хуримтлагдсан үр дүн	1.4 Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	1.1.1.1.1.1 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	702590.37	702590.37
3	1.1.1.1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл	702590.37	702590.37
9	1.1.1.1.7 Тайлант үеийн үр дүн	-10831064.23	-10831064.23
10	1.1.1.1 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-10128473.86	-10128473.86
11	1.1.1 2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	-10128473.86	-10128473.86
12	1.1.2 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-702590.37	-702590.37
13	1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-10831064.23	-10831064.23
19	1.7 Тайлант үеийн үр дүн	-32209478.63	-32209478.63
20	1 2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	-43040542.86	-43040542.86

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(Төгрөгөөр)

Дансны код	Дансны нэр, төрөл	1. Өмнөх он	2. Тайлант он
I	1.1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	156408465	395593967.9
12	1.1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	156408465	395593967.9
120	1.1.1.1.04.1 Нийтлэг татварын бус орлого	156408465	395593967.9
120013	1.1.1.1.04.1.10 Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого /ТӨҮГ/	156408465	395593967.9
II	1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	156409465	395594267.9
21	1.1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ	156409465	395594267.9
210	1.1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	156409465	395594267.9
2101	1.1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	62293963	0
210101	1.1.1.2.01.1.01.01 Үндсэн цалин	62293963	0
2102	1.1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	15100405	0
210206	1.1.1.2.01.1.02.06 Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	15100405	0
2103	1.1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	17116669	40523909
210301	1.1.1.2.01.1.03.01 Гэрэл, цахилгаан	17116669	0
210305	1.1.1.2.01.1.03.05 Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/	0	40523909
2104	1.1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал	18953494	340231756
210402	1.1.1.2.01.1.04.02 Тээвэр, шатахуун	18953494	0
210409	1.1.1.2.01.1.04.07 Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө /ТӨҮГ/	0	23999377
210410	1.1.1.2.01.1.04.08 Бараа материал худалдан авахад төлсөн /ТӨҮГ/	0	316232379
2108	1.1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	0	14838602.85
210815	1.1.1.2.01.1.08.10 Хүүний төлбөр төлсөн /ТӨҮГ/	0	59894.85
210816	1.1.1.2.01.1.08.11 Татварын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	0	14778708
2109	1.1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал	42944934	0
210901	1.1.1.2.01.1.09.01 Бараа үйлчилгээний бусад зардал	42944934	0
III	1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	-1000	-300
VIII	1.1 НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-1000	-300
101	1.2 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	10000	9000
20	1 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	9000	8700

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 201,135.8 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 2,250.0 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдааг залруулж, баталгаажуулав. Үүнд:

- ✓ Худалдаж авсан 3 теннисний ширээг данс бүртгэлд тусгаагүй 2,250.0 мянган төгрөгийн хөрөнгийг бүртгүүлэв.

Дээрх алдааг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.10-д “аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх” заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул тайланд залруулсан.

Залруулагдаагүй 198,885.8 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс их, аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн мэдэгдэхүйц нөлөөллийг тооцон “Сөрөг” дүгнэлт өгсөн.

Аудитаар илэрсэн зөрчилд 57,067.6 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 5 зөвлөмж, 141,818.1 мянган төгрөгийн 1 хариуцлага тооцуулах албан шаардлага өглөө.

3.1 АЛБАН ШААРДЛАГА:

3.1.1 Илрүүлэлт: Цэцэг сумын ОНХС-аас олгосон үйл ажиллагааны санхүүжилтээр автомашин худалдан авахдаа тендер зарлалгүйгээр шууд худалдан авалт хийсэн байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3. “Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно” 10.12 “Энэ хуулийн 10.2, 34.1-д заасан төсөвт өртгийн дээд хязгаарыг Засгийн газар тогтооно”, “МУ-ын Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 02 дугаар тогтоол”-ын хавсралт дахь заалттай нийцээгүй, санхүүгийн тайлангийн аудитын эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: ТБОНӨХБАҮХАТ хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1. “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийг зөрчсөн ажилтан, албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол буруутай албан тушаалтанд Төрийн албаны тухай хуулийн 48.1, хөдөлмөрийн гэрээтэй ажилтанд Хөдөлмөрийн тухай хуулийн 123.2-т заасан сахилгын шийтгэлийг зөрчлийн шинж байдалд тохируулан ногдуулна.” Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1.”Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно” гэсний дагуу хариуцлага тооцуулах албан шаардлага бичив.

3.2 ЗӨВЛӨМЖ

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

3.2.1 Өр төлбөртэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант онд ААНОАТ, НӨАТ-ийн өр 33,832.4 мянган төгрөгөөр өссөн байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", Төсвийн тухай хуулийн 6.4.8. “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалтуудтай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Авлага, өр төлбөрийг 2026 онд багтаан барагдуулах, төсвийг зохистой удирдаж нэмж өр авлага үүсгэхгүй ажиллах.

3.2.2 Цалингийн нэмэгдэлтэй холбоотой асуудал:

Илрүүлэлт: Төрийн захиргааны болон үйлчилгээний албан тушаалд хамаарахгүй албан тушаалтнуудад орон нутгийн нэмэгдэл тооцон олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", Засгийн газрын 2024 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 82 дугаар тогтоолын хавсралт 2.1. "Орон нутагт ажилласны нэмэгдлийг хөдөөгийн сум (тосгон)-д ажиллаж байгаа төрийн захиргааны, үйлчилгээний болон улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчид тухайн эрхэлж байгаа албан тушаалын үндсэн цалингийн 40 хувиар, аймгийн төв болон нийслэлийн алслагдсан Багануур, Багахангай, Налайх дүүрэгт ажиллаж байгаа төрийн захиргааны, үйлчилгээний болон улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчид тухайн эрхэлж байгаа албан тушаалын үндсэн цалингийн 20 хувиар тус тус бодож, сар бүр олгоно" гэсэн заалтуудтай нийцээгүй, санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Орон нутгийн нэмэгдэл тооцон олгогдох эрхгүй албан тушаалтнуудад нэмэгдэл олгож байгаа зөрчлийг таслан зогсоох.

3.2.3 Түрээсийн гэрээтэй холбоотой асуудал:

Илрүүлэлт: Түрээсийн гэрээнд үйл ажиллагаа явуулаагүй буюу хүндэтгэн үзэх шалтгаанаар түрээсийн төлбөрөөс чөлөөлөх заалт ороогүй байхад 2 түрээслэгчийн 4 сарын төлбөрийг дутуу төвлөрүүлсэн. Түрээсийн гэрээнд 300.0 мянган төгрөгийн барьцаа хадгалуулахаар заалт байгаа боловч хэрэгжихгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.1.4-д "Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажуулаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх", гэсэн заалтуудтай нийцээгүй, санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Түрээсийн гэрээг хууль журамд нийцүүлж шинэчлэн батлах, гэрээний хэрэгжилтэд тавих дотоод хяналтыг сайжруулах.

3.2.4 Төлөвлөгөө гүйцэтгэлтэй холбоотой асуудал:

Илрүүлэлт: 2025 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулан батлуулаагүй нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3 "төрийн өмчит хуулийн этгээдээс дагаж мөрдөх төлөвлөлт, ашиг орлогын хуваарилалтыг холбогдох байгууллагатай тохиролцон тогтоох;" 20.1.3/ "үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах"; гэсэн заалттай нийцээгүй, санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Байгууллагын зорилтот түвшний төлөвлөгөө боловсруулан эрх бүхий албан тушаалтнаар батлуулж мөрдөн ажиллах.

3.2.5 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал:

Илрүүлэлт: Шилэн дансны мэдээллийн системд мэдээлбэл зохих мэдээллийг байршуулаагүй, хоосон мэдээлсэн зөрчил нь Шилэн дансны тухай хуулийн 3.1.1. "төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд", 4.1.4. "хуулийн дагуу нууцад хамааруулснаас бусад бүх мэдээлэл нээлттэй байх" гэсэн заалтуудтай нийцээгүй, санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллаж, хуулийн дагуу мэдээлэгдэх бүх мэдээллийг нээлттэй ил тод мэдээлж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д "Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-г заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ"

гэж заасны дагуу зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 2026 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн дотор fas.audit.mn системд тайлагнан ажиллана уу.

Шийдвэрийн хэрэгжилтийг бүрэн хангуулж биелэлтийг Fas.audit.mn цахим системд нотлох баримтын хамт тайлагнан, Ховд аймаг дахь Төрийн аудитын байгууллагад 2026 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

4.1. Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

(мянган төгрөгөөр)

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдааны утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								тоо	Дүн	тоо	Дүн		
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
Мянган сүтэйн буян ОНӨААТҮГ	Хөрөнгө дутуу бүртгэсэн.	1	2,250.0	1	2,250.0			1	2,250.0				
Нийт дүн		1	2,250.0	1	2,250.0			1	2,250.0				

4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:								
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хуульд		
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	
Мянган сүтэйн буян ОНӨААТҮГ	Тайлант онд ААНОАТ, НӨАТ-ийн өр 33,832.4 мянган төгрөгөөр өссөн байна.	1	33,832.4					1	33,832.4			
	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй.	1	-					1	-			
	Түрээсийн гэрээнд үйл ажиллагаа явуулаагүй буюу хүндэтгэн үзэх шалтгаанаар түрээсийн төлбөрөөс чөлөөлөх заалт ороогүй байхад 2 түрээслэгчийн 4 сарын төлбөрийг дутуу төвлөрүүлсэн. Түрээсийн гэрээнд 300 мянган төгрөгийн барьцаа хадгалуулахаар заалт байгаа боловч хэрэгжихгүй байна.	1	800.0						1	800.0		
	2025 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулан батлуулаагүй	1	-						1	-		

	Төрийн захиргааны болон үйлчилгээний албан тушаалд хамаарахгүй албан тушаалтнуудад орон нутгийн нэмэгдэл тооцон олгосон.	1	22,435.2					1	22,435.2		
	Худалдан авах ажиллагаа зарлаагүй 3 ширхэг автомашиныг шууд худалдан авалт хийсэн. Худалдан авалтын НӨАТ шивүүлээгүй.	1	141,818.1			1	141,818.1				
Нийт дүн		7	198,885.8			1	130,000.0	6	68,885.8		

5. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
	НИЙТ	1	1			1			